

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
ХАГАС ЖИЛ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ИЖ БҮРЭН ШИНЭЧИЛЖ, УЯЛДАА ХОЛБООТОЙ, ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ.							
1.1	Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.	-	Арга хэмжээний хэрэгжилт, хувь	50	100	Зорилтын хэрэгжилт 69.2 хувьтай байна.	
1.1.1	Газрын хуулиудын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	-	Хуулийн төслийн тоо	-	4	- Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн барихыг дэмжсэн. Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгтэй хэрэгжиж буй “Стрийм” төслийн дэмжлэгтэйгээр Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулахаар зөвлөх хуульч нартай хамтран ажиллаж байна. Хуулийн төслийг хэлэлцүүлж санал авах ажлын хүрээнд 21 аймгийн орон нутгийн удирдлагууд, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, төрийн бус байгууллагатай хамтарсан нийт 95 хэлэлцүүлгийг зохион байгуулж 10391 хүн оролцож 14652 санал авсан. Хэлэлцүүлгээс гарсан саналын товёгийг хөтөлж, тайланг нэгтгэн, саналыг	50

						<p>тусгасан эсэх тайлбарыг гарган байгууллагын www.egazar.gov.mn сайтад байршуулсан.</p> <p>- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, 2026 оны 1/1009 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төсөлд иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудаас санал авах, цахим хэлэлцүүлэг өрнүүлэх зорилгоор https://www.d-gov.mn/ цахим системд хуулийн төслийг байршуулан, 107 иргэний дэмжсэн санал авсан байна.</p> <p>-Газрын төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, газрын төлбөрийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/63 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газар хүргүүлсэн. Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 21 аймаг, 330 сумын Засаг даргын Тамгын газар, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагчдыг хамруулсан 100 гаруй хүнд цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, цахим санал асуулгаар нийт 45 санал ирснийг тусгаж, саналын товьёг боловсруулсан.</p>
			Үзэл баримтлалын тоо	-	4	Засгийн газрын бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Газрын тухай хууль болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийн

						<p>үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээний хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 1/1145 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>-Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлуулсан.</p> <p>-Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн үзэл баримтлалыг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар тус газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 1/1009 дүгээр албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>-Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн ажлын тайланг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/63 болон 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 1/1346 дугаартай албан бичгүүдээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	
1.1.2	Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	-	Хуулийн төслийн тоо	2025 онд Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан	1	Хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг 2 удаа буюу 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр болон 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр тус тус батлуулсан. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар 2026 оны 04 дүгээр 08-ны	70

						өдрийн 1/1010 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хуулийн үзэл баримтлал батлагдсаны дараа хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	
1.1.3	Геодези, зураг зүйн тухай тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах	-	Хуулийн төслийн тоо	2025 онд Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан	1	Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/977 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дагалдах хуулийн төсөл, саналын товьёг бусад бүрдэл баримтыг хавсарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 1/1252 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 128 дугаар захирамжаар Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсгийн хуралд танилцуулах танилцуулгыг бэлтгээд байна.	80
1.1.4	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийн боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	-	Хуулийн төслийн тоо	2025 онд Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан	1	Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг Ажлын хэсгийн 5 удаагийн хурлаар боловсруулж, 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1128 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай анхдагч хуулийн төслийн дагалдах баримт бичгийг шинэчлэн боловсруулсан.	70

						Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгах зорилгоор хэлэлцүүлгийг 3 үе шаттайгаар зохион байгуулсан.	
1.1.5	Газар зүйн нэрийг өөрчлөх, шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах	-	УИХ-ын тогтоолын тоо	-	1	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр өргөн барьж, Дэд Ажлын хэсгийн хурлыг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Байгаль орчин, хүнс хөдөө, аж ахуйн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, УИХ-аар хэлэлцэхийг 68.2 хувийн саналаар дэмжсэн. Улсын Их Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, гишүүдийн 78.4 хувийн саналаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг дэмжсэн. Байгаль орчин, хүнс хөдөө, аж ахуйн байнгын хороон дээр байгуулагдсан Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн Ажлын хэсгийн 1-р хурал 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулагдсан. Улсын Их Хурлаас батлуулахаар хүлээгдэж байна.	80
1.1.6	Засгийн газрын тогтоолын төслийг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулж, батлуулах	-	Батлагдсан тогтоолын тоо	-	3	2026 оны 2 дугаар сарын 09-ны өдрийн А/47 дугаартай тушаалаар "Үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 173 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар судалгаа хийж, тогтоолын төсөл боловсруулж, "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" тогтоолын төслийг батлуулахаар Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох материалын хамт 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 1/1343 дугаартай	

			Тогтоолын төслийн тоо	-	1	<p>албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн Хэнтий аймгийн Жаргалтхаан, Баянмөнх, Дорноговь аймгийн Замын-Үүд, Дэлгэрэх, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц, Буянт, Сагсай сумд болон Хархорум хотын эдэлбэр газарт нийт 13064 га атар газрыг тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг дэмжин уламжилсныг судлан үзэж, холбогдох давхцал зөрчлийг арилгуулан, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1/766 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>-Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл /бүс/, суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоолоор баталсан газрын суурь үнэлгээг шинэчлэн тогтоох Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.</p> <p>-Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар судалгаа хийж, тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.</p>	83.3
1.1.7	Салбарын журам, заавар, аргачлалын шинээр төслийг	-	Батлагдсан журмын тоо	-	3	-Салбарын кибер аюулгүй байдлыг хангах дотоод журам”-ын төслийг боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдөр	

	боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, батлах					хэлэлцүүлэн, зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн санал, зөвлөмжийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусган засварлаж, хянаж байна. -2024 оны А/183 дугаар тушаалаар “Салбарын мэдээллийн технологийг ашиглах дотоод журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж байна.	58.3
		-	Батлагдсан Зааврын тоо	-	2	Байгууллагын дата төвд ашиглагдаж буй сервер, төхөөрөмжтэй харьцах аюулгүй ажиллагааны дүрэм, ослын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө, заавар боловсруулж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалт авах чиглэлээр 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/1647 дугаартай албан бичгийг хүргүүлсэн.	
		-	Батлагдсан аргачлалын тоо	-	2	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, Байгууллагын эрсдэлийн удирдлагын үнэлгээ хийх аргачлалыг тус тус батлуулсан. “Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний аргачлал”-ын төслийг боловсруулж байна.	
1.1.8	Салбар дундын мөрдөх журмыг шинэчлэн боловсруулж, хамтран батлах	-	Журмын төслийн тоо	-	2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай хамтарсан 2026 оны А/18, А/37 дугаар тушаалаар "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам"-ыг боловсруулахаар байгуулагдсан ажлын хэсгийн 6 удаагийн хурал зохион байгуулж, төсөлд холбогдох 34 саналыг тусган эцэслэн боловсруулсан. Тус журмын төслийг Газрын болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын	70

						<p>гишүүд хамтран батлахаар заасан байдаг бөгөөд журмын төсөлд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам холбогдох хурал болон Сайд, төрийн нарийн бичгийн даргадаа танилцуулж санал авахаар хүлээгдэж байна.</p>	
1.1.9	Норм, дүрэм боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах	-	Батлагдсан дүрмийн тоо	4	4	<p>Салбарын үйлчилгээний стандартыг боловсруулж, 2026 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/62 дугаар тушаалаар баталсан.</p> <p>“Солбицлын дэд тогтолцоог тогтоох, улсын солбицлын тогтолцоонд шилжүүлэх хөрвүүлгийн утгыг тодорхойлох” дүрмийг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/97 дугаар тушаалаар баталсан.</p> <p>“Авто зам болон төмөр замын геодезийн ажил БНБД” дүрмийг батлуулах тухай 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 1/833 дугаар албан бичиг Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.</p> <p>“Усны ёроолын геодезийн ажил БД” болон “Хот суурин газрын өндөржилт төлөвлөлтийн геодезийн ажил БД” дүрмийн төслийг Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр 05 дугаар сарын 28-ны өдрийн 1/1617 дугаар албан бичиг хүргүүлсэн.</p>	80
1.1.10	Олон улсын ISO стандартыг боловсруулж батлуулах	-	Стандартын тоо	=	4	<p>Олон улсын хаягжуулалтын ISO стандартын орчуулгын ажлыг, 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас Олон улсын хаягжуулалтын 4 цуврал ISO 19160 стандартыг англи хэлнээс монгол хэл рүү орчуулсан орчуулгын төсөлд редакц хийлгэн, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан боловч санхүүжилтийг</p>	50

						2026 оны төсвийн тодотголд оруулж 8 сард шүүмж хийлгүүлэхээр болсон. Мөн 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр 1/1631-1/1636 дугаартай албаар бичгээр холбогдох газруудад стандарт орчуулгын төсөлд санал авахаар албан бичиг хүргүүлсэн.	
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2. ОРОН ЗАЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ, НОТӨЛГӨӨНД СУУРИЛСАН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ДАМЖУУЛЖ ГАЗРЫН НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛАХ ЗАМААР УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦСОН, ТОГТВОРТОЙ ГАЗАР АШИГЛАЛТЫГ БИЙ БОЛГОНО.							
2.1	Хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, аж ахуйн нэгжийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, үүнтэй уялдуулан төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Төлөвлөгөө ний баримт бичигтэй аймгийн тоо	19	21	Зорилтын хэрэгжилт 91.7 хувьтай байна.	
2.1.1	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр	Төлөвлөгөө боловсруулан аймаг, сум, нийслэл, дүүргийн тоо	396	400	Увс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянан баталсан. Увс, Дундговь аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн. Хэрэгжих хугацаа дууссан Өвөрхангай аймгийн ерөнхий төлөвлөгөөний тайланг хянаж Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн нэгдүгээр хурлаар хэлэлцүүлэн, дараагийн шатны хурлаар хэлэлцүүлэхийг дэмжих тухай шийдвэрийг гаргуулан дүгнэлт зөвлөмжийг гүйцэтгэгчид өгч ажилласан. Хагас жилд 8 аймгийн 23 сумын сумын төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянаж, төлөвлөгөө боловсруулж байгаа 4 аймгийн 11 сумын	100

						нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргаж, нийт 407 сум төлөвлөгөө боловсруулсан.	
2.1.2	“Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай”, “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, батлуулах	-	Засгийн газрын тогтоолын тоо	2	1	Улсын хэмжээнд 2026 онд иргэдэд өмчлүүлэх газрын саналыг сум, дүүрэг тус бүрээр хэлэлцэн баталж ирүүлснийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан шалгаж, давхцал, зөрчлийг арилгуулан Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 1/374 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 46 дугаар тогтоолоор “Монгол Улсын иргэнд 2026 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт”-ыг баталсан. Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 1/140 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоолоор “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт”-ыг баталсан.	100
2.1.3	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, өсөлтийн үр өгөөжийг иргэдийн амьжиргаанд хүртээмжтэй хүргэх талаар авах багц арга хэмжээний төлөвлөгөөний	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Эдийн засгийн өсөлтийг иргэддээ хүргэх 300 хоногийн төлөвлөгөө"-д тусгагдсан агентлагийн хэрэгжүүлэх зорилтын биелэлтийг хангах ажлын төлөвлөгөөг 2026 оны А/70 дугаар тушаалаар баталж, 21 аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2026 оны 1/615 дугаар бичгээр хүргүүлсэн.	50

	хэрэгжилтийг хангаж, тайлагнах					Төлөвлөгөөний 1-р улирлын хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Эдийн засаг хөгжлийн яаманд бичмэл тайлан болон танилцуулгын хамт хүргүүлсэн. Засгийн газрын “Эдийн засгийн өсөлтийг иргэддээ хүргэх 300 хоногийн ажлын төлөвлөгөө”-ний 4-р сарын байдлаар хэрэгжилтийн тайланг нэгтгэж хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн.	
2.1.4	Улсын хэмжээнд Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор байгуулагдсан улс, орон нутгийн чанартай хотуудын эдэлбэр газрыг тогтоох ажлыг зохион байгуулж, тогтоолын төслийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	-	Улсын Их Хурлын тогтоолын төслийн тоо	-	1	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улс, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тодорхойлох” үүрэг бүхий ажлын хэсэгт Монгол Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой судалгаа мэдээлэл, тогтоолын төслийг боловсруулж ажлын хэсэгт 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр танилцуулсан. Тус тогтоолын төсөл, эдэлбэр газрыг тогтоох судалгаа мэдээлэл болон УИХ-ын 72 дугаар тогтоолын хэрэгжилтийг Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний хуралдаанд ажлын хэсгээс танилцуулсан. "Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.	100
2.1.5	Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	95	100	1. Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт 651.2 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын	

					<p>23-ны өдрийн 1/1177 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн. Дорнод аймгийн Халхгол сумын нутаг дэвсгэр дэх Хөдөө аж ахуйн “Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс”-ийн 500 мянган га газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг боловсруулан 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 1/1618 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>2.Монгол наадам цогцолбортой холбоотой "Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцах гэрээ"-г шинэчлэн байгуулахаар гэрээний төслийг боловсруулан санал авахаар Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Аргалант сумын Засаг даргад 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/942, 1/963, 1/964 дугаартай албан бичиг, Дархан-Уул аймгийн ургамал газар тариалантай холбоотой "Улсын тусгай хэрэгцээний газрын ашиглалтыг хариуцах гэрээ"-г байгуулахаар гэрээний төслийг боловсруулан санал авахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1/918 дугаартай албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн. Хархорум хот, хийн хоолойтой холбоотой гэрээний тухай асуудалд чиглэл авахаар 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 1/1478, 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1/1580 дугаартай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>3.“Улсын тусгай хэрэгцээний газрын газар</p>	100
--	--	--	--	--	---	-----

						ашиглалтын төлөвлөгөө"-г боловсруулах жишиг ажлын даалгаврын төслийг боловсруулсан.	
2.1.6	Байгаль орчны төлөвлө байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэх	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	98	100	Аймаг, нийслэлийн газрын нэгдмэл сангийн тайланг хүлээн авч нэгтгэн, улсын нэгдсэн тайланг гаргаж, тус газрын 2026 оны 1/562 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Монгол улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хурлаар танилцуулагдсан. Хуралдаанаас гарсан тэмдэглэлийн хүрээнд 21 аймгийн Засаг дарга нарт хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах талаар 2026 оны 1/1037 дугаар албан бичгийг хүргүүлж ажилласан. Түүнчлэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд газрын нэгдмэл сангийн ангилалд хамаарах газрын мэдээллийг дундын мэдээллийн сангаар дамжуулан солилцон, хамтран ажиллах тухай 2026 оны 1/1046, 1/1047 дугаар албан бичгийг хүргүүлж ажилласан. Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг нэгтгэн Байгаль орчны мэдээллийн сан www.eic.mn цахим платформд оруулсан.	100
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 3. ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ГАЗРЫН БИРЖ, ҮНЭЛГЭЭ, ТАТВАР, ТӨЛБӨРИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ИЛ ТОД, НАЙДВАРТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ.							
3.1	Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг “блокчейн” технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.	-	Систем хөгжүүлэлтийн хувь	70	100	Зорилтын хэрэгжилт 43.8 хувьтай байна.	

3.1.1	Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалт төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж батлуулах	-	Батлагдсан ТЭЗҮ-ийн тоо	-	1	2020 онд батлагдсан “Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалт төлөвлөлт, хяналтын системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх” техник эдийн засгийн үндэслэлийн программ хангамжийн үзүүлэлтийн судалгааг хийж, мөн зардлын тооцоог шинэчлэн боловсруулсан. Техник, эдийн засгийн үндэслэлийг төлөвлөгөөний дагуу 4 дүгээр улиралд батлуулна.	20
3.1.2	Газрын тухай хууль болон Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд олгох газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг Газрын биржийн цахим системээр, газрын төлбөр, татварыг цахим системээр дамжуулан бүрэн ногдуулах ажлыг зохион байгуулах, системийн хэвийн үйл ажиллагааг хангах	-	Системд бүртгэсэн дуудлага худалдаа ,төсөл сонгон шалгаруулалтын хувь	85	90	Тайлант хугацаанд нийт 2455 газрыг дуудлага худалдаагаар олгохоор төлөвлөснөөс 1571 газарт дуудлага худалдаа зохион байгуулагдсан. Нийт зохион байгуулагдсан дуудлага худалдааны 1264 нь цахим хэлбэрээр, 307 нь танхимаар зохион байгуулагдсан. Дуудлага худалдаанд нийт 3443 иргэн, хуулийн этгээд оролцож, 10.2 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн. Мөн тус онд нийт 579 газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөснөөс 202 газрын төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар Газрын биржийн цахим системд бүртгэсэн, 34 газрын төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дууссан бөгөөд нийт 34 иргэн, хуулийн этгээд оролцсон. Нийт зохион байгуулсан төсөл сонгон шалгаруулалтын 33 нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд өрнүүлж байгаа малчдын “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт эзэлж байна.Газрын төлбөрийн хувьд улсын хэмжээнд нийт 573,982 хүчинтэй гэрээнд 173,8 тэрбум төгрөгийн ногдуулалт үүсгэж үүнээс 532,862 гэрээнд 171.2 тэрбум төгрөгийн нэхэмжлэл үүсгэн татварын удирдлагын	67.6

						нэгдсэн системд илгээсэн. Харин газар үл хөдлөх хөрөнгийн албан татвар ногдуулах ажлын хүрээнд улсын хэмжээнд 255,057 нэгж талбарын өмчилсөн газарт татвар ногдуулалт хийж, 200,068 нэгж талбарт нэхэмжлэл үүсгэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн.	
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 4. ГАЗРЫН МОНИТОРИНГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, ДОРОЙТСОН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭНЭ.							
4.1	Төрийн өмчийн газрын хяналт, мониторингийг сайжруулж, газрын мониторингийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.	-	Хяналт мониторинг нэвтрүүлсэн газар нутгийн эзлэх хувь	24.9	32.8	Зорилтын хэрэгжилт 41.7 хувьтай байна.	
4.1.1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг зохион байгуулж, хяналт тавих, ажлын үр дүнгээр үүссэн тоон мэдээллээр газрын мониторингийн цахим системийг баяжуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	98	100	Улсын хэмжээнд 12 аймгийн 36 сумын бэлчээр, тариалан болон хот, тосгон, бусад суурины нийт 1,233,941.15 га талбайг хамруулсан 850 мониторингийн цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулахаар ажлын даалгаврыг хянаж, холбогдох аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	50
4.1.2	2026 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын үр дүнгээр улсын нэгдсэн тайланг боловсруулж, холбогдох зөвлөмж, чиглэлийг хүргүүлэх	-	Фото мониторингийн цэгийн тоо	5253	5253	Хугацаа болоогүй	-
4.1.3	Маш хүчтэй доройтсон газрын ашиглалтыг нэгдмэл сангийн ангиллаар тодорхойлох, нөхөн сэргээх	-	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, сая га	5	6.1	Газрын төлөв байдал, чанарын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, 3,540,453.0 га газарт доройтол, хохирол үүссэнийг газрын нэгдмэл сангийн ангиллаар тодорхойлов. Үүнээс бэлчээрийн газар 3,190,559.0 га, ойн сан	11.8

						<p>бүхий газар 250,124.8 га, хот, тосгон, бусад суурин газрын 55,815.4 га, тариалангийн газрын 37,638.3 га, усны сан бүхий газрын 4,324.5 га, зам, шугам сүлжээний газрын 1,450.7 га, улсын тусгай хэрэгцээний газрын 540.2 га талбай тус тус доройтож, хохирол учирсан нь тогтоогдсон.</p> <p>Доройтлын түвшин, газар ашиглалтын зориулалт, газрын нэгдмэл сангийн ангилалд үндэслэн маш хүчтэй доройтсон газрын байршил, хэмжээ, хамрах хүрээг тодорхойлж, нөхөн сэргээх, хамгаалах шаардлагатай талбайнуудыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үе шаттайгаар тусган 129,367.19 га талбайд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлээд байгаа бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>	
4.1.4	Газар хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	-	Гүйцэтгэлийн хувь	90	95	<p>Улсын хэмжээнд 2026 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд газар хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн нийт 750 нэгж талбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Нөхөн сэргээх ажил дулааны улиралд хурдацтай явагддаг ба бэлчээр, ой, усны сан бүхий газар, усны эх үүсвэр, суурин газрын орчныг хамгаалах, доройтсон болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, бэлчээрийн ашиглалтыг зохистой болгох, мод, бут сөөг тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усны эх булаг болон эрэг орчмын хамгаалалтын бүсийг тохижуулах, уул уурхай болон дэд бүтцийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зэрэг арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Эхний хагас жилийн байдлаар 35 нэгж талбарт газар хамгаалах, нөхөн сэргээх арга</p>	5

						хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Зуны улиралд н газар хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн арга хэмжээг түргэвчлэхэд анхаарч ажиллаж байна.	
4.1.5	Газрын мониторингийн цахим системд сумын төвүүдэд хийгдсэн дроноос авсан агаарын зургийг оруулж, баяжуулах	-	Мэдээллийн санд оруулсан зургийн тоо	2	41	Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн нийт 17 хэсэгт хамаарах 4,124.0 га талбай, Улсын хэмжээнд 37 сумын 7935.4 га талбай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн сонгогдсон сумдын төвийн 3262 га талбайд орон зайн мэдээллийн санг баяжуулах ажлын хүрээнд нийслэлийн 5 дүүрэг, 9 аймгийн 45 сумын төвд дроноор авсан өндөр нарийвчлалтай ортофото зургуудыг Газрын мониторингийн цахим системд оруулсан. Ингэснээр нийт 15,321.4 га хот суурин газрыг хамарсан өндөр нарийвчлалтай ортофото зургийн мэдээллээр Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санг баяжуулж, газар ашиглалт, газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын мониторингийн судалгаа, шинжилгээ, хяналт үнэлгээний ажлыг илүү нарийвчлалтай, шуурхай хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.	100
4.2	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, газрын харилцааны салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.	-	Хэрэгжилтийн хувь	90	95	Зорилтын хэрэгжилт 97.5 хувьтай байна.	
4.2.1	21 аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 345 объектод төлөвлөгөөт хяналт	-	Объектын хамрагдалтын хувь	90	95	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг цуцалсан.	-

	шалгалт хийх, эрсдэлийн түвшин бууруулж, улсын байцаагийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах						
4.2.2	Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын хэрэгжилт хангуулах, хяналт шалгалт хийх	-	Хамрагдсан аймгийн тоо	21	21	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг цуцалсан.	-
4.2.3	Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	-	Өргөдөл шийдвэрлэсэн хувь	85	90	Тайлант хугацаанд улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтын 56 удирдамж батлуулж, хяналт шалгалтад 13020 нэгж талбар хамрагдсан. Үүнээс 63 иргэн, хуулийн этгээдэд хугацаатай албан шаардлага, 55 зөвлөмж, албан даалгавар 36, дүгнэлт 1, мэдэгдэл 170 өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 349 иргэн, хуулийн этгээдэд 365,6 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийг арилгуулж ажилласан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны X/129 дугаартай “Хамтран ажиллах тухай” албан бичгийн хүрээнд “Дорноговь аймгийн Замын-Үүд чөлөөт бүсэд хяналт шалгалтыг гүйцэтгэж 2026 оны 03 дугаар сарын 11-ний 1/686 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 35-00/02/01 дугаартай хяналт шалгалтын танилцуулгыг хүргүүлсэн. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2026 оны 10/2154 дугаартай албан бичгээр ирүүлсэн	90

						<p>гомдлын дагуу Салбарын улсын ахлах байцаагчийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 35-00/10 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг батлуулсан. Тус удирдамжийн дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэн, дүгнэлтийг 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 2/1300 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Иргэн Д.Баттулгаас ирүүлсэн өргөдлийн дагуу Салбарын улсын ахлах байцаагчийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 35-00/11 дугаартай “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг батлуулсан. Тус удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэн, зөрчлийг арилгаж иргэн Д.Баттулгад 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 2/1398 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.</p> <p>Улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 35-00/05, 35-00/13, 35-00/12 дугаартай удирдамжийн хүрээнд Налайх, Багахангай, Багануур, Хан-Уул дүүргийн хэмжээнд 2020-2025 онуудад эрх бүхий этгээдийн шийдвэрээр газар эзэмшүүлж, ашиглуулсан байдалд хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.</p>	
4.2.4	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах	-	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд улсын хэмжээнд хялбаршуулсан журмаар 239 иргэнд 109,780 сая төгрөг, 42 аж ахуй нэгж байгууллагад 204,400 сая, нийт 314,180 сая төгрөгийн торгууль, хохирол, нөхөн төлбөрийн 42,874 сая төгрөгийн мөнгөн дүн улсын төсөвт төвлөрүүлсэн. 4 зөрчлийн хэрэг шүүхийн журмаар шийдвэрлэсэн. Эрх бүхий албан тушаалтны зөрчлийн үр дагаврыг арилгах даалгаврыг сайн дураар биелүүлээгүй 5</p>	100

						иргэн, хуулийн этгээдэд албадлагын арга хэмжээ авсан. ezurchil.gov.mn “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д Баянхонгор аймгийн Улсын ахлах байцаагчийн эрх, Булган аймгийн Улсын байцаагчийн эрхийн бүртгэлийг үүсгэж өгсөн. Системтэй холбоотой асуудалд тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Ezurchil.gov.mn нэгдсэн санд 47 улсын байцаагч (ахлах) нарт системд хандах эрх олгосон.	
4.2.5	Салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	-	Хяналт шалгалтын тоо	40	8	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг цуцалсан.	-
4.2.6	Салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах, мэдээллийн санг эрхлэх	-	Шийдвэрлэлтийн хувь	98	100	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн 66 хүсэлтээс 39 байгууллага сунгуулж, 19 байгууллага шинээр авч, нийт 58 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосон. Шаардлага хангуулахаар 2 байгууллагын хүсэлтийг буцааж, 6 байгууллага давхардуулан хүсэлт ирүүлсэн үндэслэлээр буцаагдсан. Хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл байхгүй. Газар зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрх олгох тусгай зөвшөөрлийн 39 хүсэлтээс 22 байгууллага сунгуулж, 9 байгууллага шинээр авч, нийт 31 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосон. Шаардлага хангуулахаар 2 байгууллагын хүсэлтийг буцааж, 6 байгууллага давхардуулан	100

						хүсэлт ирүүлсэн үндэслэлээр буцаагдсан. Хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл байхгүй. Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох тусгай зөвшөөрлийн 10 хүсэлтээс 2 байгууллага сунгуулж, 2 байгууллага шинээр авч, нийт 4 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосон. Шаардлага хангуулахаар 4 байгууллагын хүсэлтийг буцааж, 2 байгууллага давхардуулан хүсэлт ирүүлсэн үндэслэлээр буцаагдсан. Хүчингүй болгосон тусгай зөвшөөрөл байхгүй.	
4.2.7	Улсын байцаагчийн эрх олгох, цуцлах ажлыг зохион байгуулах	-	Шийдвэрлэлтийн хувь	95	100	-Ерөнхий сайдын 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 13 дугаар захирамжаар 1 улсын ахлах байцаагчийн эрхийг цуцалж, 1 улсын байцаагчийн эрхийг улсын ахлах байцаагч болгож, 1 улсын ахлах байцаагчийн эрхийг олгосон. -Ерөнхий сайдын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 29 дүгээр захирамжаар 1 улсын ахлах байцаагчийн эрхийг, 1 улсын байцаагчийн эрхийг тус тус цуцалж, 1 улсын ахлах байцаагчийн эрхийг олгосон. - Ерөнхий сайдын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 47 дугаар захирамжаар 1 улсын ахлах байцаагчийн эрхийг олгосон. - Ерөнхий сайдын 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 115 дугаар захирамжаар 1 улсын ахлах байцаагчийн эрхийг цуцалж, 1 улсын ахлах байцаагчийн эрхийг олгосон. 100 хувь шийдвэрлэсэн.	100
5.1	Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн	Орон нутгийн төсөв	Байнгын ажиллагаатай	50	55	Зорилтын хэрэгжилт 40 хувьтай байна.	

	дэд бүтцийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.		й суурин станцын тоо				
5.1.1	Дэлхийн геодезийн сүлжээнд тулгуурласан Монгол Улсын геодезийн сүлжээг сайжруулах	Орон нутгийн төсөв	Батлагдсан төлөвлөгөөний тоо	Шинээр батлуулна.	1	Дэлхийн геодезийн сүлжээнд тулгуурласан Монгол Улсын өндрийн болон гравиметрийн сүлжээг сайжруулах төлөвлөгөөний төслийг боловсруулж, Ажлын хэсгийн хурлыг 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр танхим болон цахимаар зохион байгуулав. Хурлаар Монгол Улсын өндрийн болон гравиметрийн сүлжээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, төсвийн тооцоо, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлон хэлэлцүүлж, албан бичгээр ирүүлсэн 2 санал болон хурлаас гарсан саналуудыг нэгтгэж саналын товъёог гаргасан. Ажлын хэсгийн хурлаас гарсан өндрийн болон гравиметрийн сүлжээг сайжруулах саналыг тусган төсвийн тооцоог шинэчлэн гаргаж, төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	50
5.1.2	Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулах	-	Өндрийн 1-2 сүлжээний шугам, цэгийн тоо	14 шугам, 501 цэг	27 шугам, 1520 цэг	Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хил шалгах ажлын хүрээнд өндрийн болон гравиметрийн сүлжээний хэмжилт, боловсруулалтын ажлын төсвийн тооцоог гаргаж, танилцуулга бэлтгэж, 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн н/17 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн н/18 дугаар албан бичгээр Сангийн яаманд, 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн мн/19 дугаар албан бичгээр Ерөнхий Сайдад, Комиссын даргад 2 удаа тус тус хүргүүлсэн.	30
5.2	Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар	-	Зурагжуулах нутаг дэвсгэрийн талбайн	711,086	831,086	Зорилтын хэрэгжилт 88.7 хувьтай байна.	

	зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.		хэмжээ, км.кв				
5.2.1	Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий дунд масштабын байр зүйн тоон зургаар зурагжуулах	-	Зургийн тоо	-	200	1:25000-ны масштабтай байр зүйн зургийг дигитал хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 4200 хуудас зургийг GeoTIFF формат руу хөрвүүлсэн.	100
		-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	100		
5.2.2	Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий том масштабын байр зүйн тоон зургаар зурагжуулах	-	Сумын тоо (өссөн дүнгээр)	4	7	1.Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Үйлдвэрлэл паркийн зориулалттай 1:1000-ны масштабын байр зүйн дэвсгэр зураглалын ажлыг шалгаж, 2026/02 дугаартай дүгнэлт гаргасан. 2.Дорноговь аймгийн замын-үүд сумын нутагт орших "ЗАМЫН-ҮҮД" чөлөөт бүсийн талбай, улсын хилийн бүсэд гүйцэтгэх геодези, зураг зүйн ажил"-ын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг шалгаж, 2026/181 дугаартай дүгнэлт гаргасан. 3.Налайх дүүргийн "Налуу Ухаа эдийн засгийн тусгай бүсийн байр зүйн дэвсгэр зургийн ажил"-ын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг шалгаж, 2026/189 дугаартай дүгнэлт гаргасан. 4."Ховд аймгийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд зориулсан том масштабын байр зүйн зураглалын ажлын"-ын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг шалгаж, 2026/188 дугаартай дүгнэлт гаргасан. Баянхонгор аймгийн Баянлиг сумыг 1:1000-ны масштабын байр зүйн зургаар зураглах ажил, Нийслэлийн Чингэлтэй	71.4

						дүүргийг 1:500-ны масштабын байр зүйн зургаар зураглах ажлын орон нутгийн төсөв батлагдаж, шаардлагатай Ажлын даалгаврыг боловсруулан батлуулж хүргүүлсэн.	
5.2.3	Хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангах	-	Судалгааны тоо	-	1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн газрын гадаргын хэлбэрийг бодит хэлбэрээр дүрслэн үзүүлж, жижиг масштабын товгор газрын зургийг зохиох, хэвлүүлэх судалгааны эх бэлтгэл, хэвлэлийн үнийн судалгааг хийсэн.	100
5.2.4	Монгол Улс, Оросын Холбооны Улс болон Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын хилийг шалгах, зураглах ажлыг зохион байгуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	30	100	Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хил шалгах 2026 оны ажлын хүрээнд геодези, байр зүйн зураглалын төсвийн тооцоог боловсруулж, танилцуулга бэлтгэж, 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн н/17 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн н/18 дугаар албан бичгээр Сангийн яаманд, 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн мн/19 дугаар албан бичгээр Ерөнхий сайдад тус тус хүргүүлсэн. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын улсын хилийг шалгах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгсөн. Засгийн газрын тогтоол 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын хил шалгах ажлын бэлтгэл хангах Ажлын хэсгийн хурал 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Гадаад харилцааны яам дээр зохион байгуулагдаж оролцсон.	70
5.2.5	1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг	Орон нутгийн төсөв	Сумын тоо	4	3	Хот, суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 тогтолцоонд хийх ажлын нийт 4	90

	ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх					аймгийн 5 сум, 1 дүүргийн Ажлын даалгавар батлагдсан. Орхон аймгийн Баян-Өндөр, Дорнод аймгийн Хэрлэн, Баянхонгор аймгийн Баянлиг, Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумд, Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт орон нутгийн төсөв батлагдаж, шаардлагатай Ажлын даалгавар (АД-73, АД-74, АД-01, АД-12, АД-15, АД-34)-ыг тус тус боловсруулан батлуулж албан бичгээр аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн. Үүнээс 5 сумын нээлттэй тендер зарлагдаж, сонгон шалгаруулалт хийгдсэн байна. Ажлын даалгавар болон тендерийн баримт бичигтэй холбоотой зөрчил, гомдлын талаар 1/152, 1/153, 1/344, 1/346, 1/739, 1/886, 1/1015 дугаар албан бичгүүдийг тухай бүр хүргүүлсэн.	
5.2.6	Геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100	100	Геодезийн хэмжил зүйн лабораторийн нөхцөлд нийт 388ш хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулж 23 437 312 төгрөг, Жишилтийн "Яармаг" полигон дээр 2026 оны 1 дүгээр улиралд нийт 255 геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулалт хийж 16,227,485 төгрөгийн орлого бүрдүүлсэн. Үүнээс GNSS 171ш, атомат нивелир 241ш, тоон нивелир 8ш, тэнхлэг шилжүүлэгч 1ш, Электрон тахеометр 20 ш, Электрон теодолит 65 ш, Эргэгч лазер 17ш тус тус баталгаажуулж гэрчилгээ олгосон.	100
6.1	Газрын кадастрын цахим системийг бусад байгууллагуудын цахим системтэй холболт хийж иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	-	Арга хэмжээний хэрэгжилт хувь	50	70	Зорилтын хэрэгжилт 71.7 хувьтай байна.	

6.1.1	Гурав ба дөрвөн хэмжээст газрын кадастрын нэгдсэн системийг бий болгож хөгжүүлэх	-	Систем хөгжүүлэлтийн хувь	10	25	Хот байгуулалтын кадастрын цахим системийн газрын зураг модулийг webGIS технологид суурилуулан боловсронгуй болгох, гурав ба дөрвөн хэмжээст өгөгдлийн санг үүсгэх, хот байгуулалтын баримт бичиг, инженерийн шугам сүлжээний хориглолт хамгаалалтын бүс, газар, барилгын давхаргуудыг давхцуулж анализ хийх боломжтой болгох мөн төрийн бусад байгууллагатай сервис холболт хийж мэдээлэл солилцох зэрэг нэмэлт хөгжүүлэлтийн нийт 35 бүрдэл бүхий ажлын даалгаврын төслийг боловсруулж Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яаманд 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн.	50
6.1.2	Хот байгуулалтын кадастрын цахим системд барилга, инженерийн шугам сүлжээний төлөвлөлт болон Барилга байгууламж, инженерийн дэд бүтэцийн өгөгдөл, мэдээллийг бүртгэх ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөлтийн давхаргын мэдээллийн тоо	-	63	Тайлант хугацаанд хот байгуулалтын кадастрын цахим системд тэг тэнхлэг улаан шугамын 161, барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний нийт 188 гүйцэтгэлийн зургийн мэдээлэл бүртгэгдсэн. Хот байгуулалтын кадастрын цахим системээр архитектур төлөвлөлтийн болон зургийн даалгавар 977, загвар зураг 235, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл 284, барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 107 батлагдан гарсан.	100
6.1.3	Газар өмчлөх, эзэмших, ашиглах, эрхтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн 27 төрлийн хүсэлтийг цахимаар авч шуурхай шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн дундаж хоног	30-60	5-10	Иргэн, хуулийн этгээд нь газрын эрхтэй холбоотой 27 төрлийн хүсэлтийг гаргахад төрийн байгууллагуудын хооронд явж материал бүрдүүлэн өргөдөл, хүсэлт, иргэний үнэмлэх, газрын гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, төлбөрийн тооцоо нийлсэн акт зэрэг 20-30 нэр төрийн баримт бичгийг бүрдүүлж өөрийн биеэр хандаж, 30-60 хоногийн хугацаанд шийдвэрлүүлдэг үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор 2026 оны 1 дүгээр улиралд Газрын нэгдмэл сангийн удирдлагын	90

						<p>нэгдсэн цахим системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх, чөлөөлөх, газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх, эзэмшиж, ашиглаж буй газрын зориулалт болон талбайн хэмжээ өөрчлөх, хугацаа сунгах, эзэмшиж буй газраа өмчлөх гэх мэт 27 төрлийн хүсэлтийг цахимаар илгээх боломжийг бүрдүүлж хэрэглээнд бүрэн нэвтрүүлээд байна.</p> <p>Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын дагуу үйлчилгээ авахад шаарддаг байсан 10-21 төрлийн цаасан баримт бичгийг систем автоматаар үүсгэж орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахимаар хүсэлтээ гаргах боломжийг бүрдүүлсэн бөгөөд Газрын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон журамд заасны дагуу хүсэлтийг ажлын 5-15 хоногт багтаан шийдвэрлэх боломжтой болсон юм. Үүний үр дүнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар цахим системээр дамжуулан нийт 43,488 хүсэлт ирснээс 28,634 хүсэлтийг буюу 65.8 хувийг шийдвэрлэсэн байгаа бөгөөд хүсэлтийг дунджаар 16 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн байна.</p>	
6.1.4	Иргэн, хуулийн этгээдийн газрын эрх шилжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, албан татварыг цахимаар шуурхай төлөх боломжийг бүрдүүлэх	-	Цахимжуулсан хувь	-	100	<p>"Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг Татварын ерөнхий газрын "Татварын удирдлагын нэгдсэн систем"-тэй холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр иргэн, хуулийн этгээд газрын эрх шилжүүлэх хүсэлтийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ээр дамжуулан гаргах үед холбогдох</p>	100

						баримт бичгийг “Татварын удирдлагын нэгдсэн систем”-д цахимаар илгээж Газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын нэхэмжлэхийг үүсгэн цахимаар татвар төлөх боломжийг бүрдүүлсэн. Уг үйлчилгээг 2026 оны 04 дүгээр сарын 9-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлснээр газрын эрх шилжүүлэх үйл ажиллагааг 100 хувь цахим хэлбэрт шилжиж, иргэн, хуулийн этгээд нь Газрын алба, Татварын хэлтэс, Банканд биечлэн очих шаардлагагүй болж, төрийн үйлчилгээг шуурхай, хүндрэл чирэгдэлгүй авах, цаг хугацаа хэмнэх нөхцөл бүрдсэн. Үүний үр дүнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд газар эзэмших эрх шилжүүлэх нийт 7,209 хүсэлт хүлээн авч, 5,552 хүсэлтийг буюу 77 хувийг дунджаар 13 хоногт шийдвэрлэсэн байна.	
6.1.5	Хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийн 20 гаруй үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбож, иргэн, хуулийн этгээд цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх	-	Дундын мэдээллийн сангийн тоо (өссөн дүнгээр)	2	3	Төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох ажлын хүрээнд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын цахим системтэй холбох хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн хот байгуулалтын кадастрын цахим системээс архитектур төлөвлөлтийн даалгавар, эскиз загвар зураг, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн мэдээллийг илгээж үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг авах боломжтой болсон ба одоо туршилт, тест тохируулгын ажил хийгдэж байна. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим системтэй мэдээлэл солилцох хөгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэж байна.	50
6.1.6	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем дэх газрын харилцааны	-	“E-Mongolia”-д холбосон	11	13	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем дэх газрын харилцааны салбарын цахим үйлчилгээг нэмэх, шинэчлэх ажлын	40

	салбарын цахим үйлчилгээг шинэчлэх		газрын харилцааны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо (өссөн дүнгээр)			хүрээнд Хот байгуулалтын кадастрын цахим системийг e-business.mn-тэй холбох хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба тус платформоор иргэн, хуулийн этгээд нэвтрэн орж нийт 25 төрлийн хүсэлт илгээх боломжтой болсон ба цахим системээр дамжуулан иргэн, хуулийн этгээд нийт 3917 хүсэлт илгээсэн байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-д гарч буй цахим үйлчилгээг нэмэх, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор И-Монгол улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран 11 үйлчилгээ, лавлагааг хэвийн хүргэж, тусгай зөвшөөрлийн цахим систем болон бусад холбогдох системүүдэд 30 үйлчилгээг холболт (link) хийж гүйцэтгэсэн.	
		-	Төрийн үйлчилгээний цахим төхөөрөмжид холбогдсон үйлчилгээний тоо	-	19	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран Төрийн үйлчилгээний киоск цахим төхөөрөмжтэй интеграци хийж, газрын харилцааны 19 үйлчилгээ нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд 2 удаа хуралдаж, шаардлагатай мэдээллийг гарган өгч ажиллаж байна.	
7.1	Орон зайн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын оновчтой, үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.	-	Орон зайн мэдээллийн ашиглалтын хувь	10	15	Зорилтын хэрэгжилт 52.5 хувьтай байна.	
7.1.1	Монгол Улсад Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулж, батлах	-	Судалгааны тоо	-	1	Монгол Улсад Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөөг боловсруулж, батлуулах ажлын хүрээнд НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн хорооноос гаргасан аргачлалын дагуу Нэгдсэн орон зайн	55
		-	Тухайн жилийн төлөвлөгөөний	-	100		

			хэрэгжилтийн хувь			мэдээллийн хүрээ (Integrated Geospatial Information Framework)-ийн дагуу судалгааг боловсруулсан. Монгол Улсад Үндэсний Орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах, нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Герман, Япон, Австрали улсын туршлагыг судалж, орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах ач холбогдол, тогтвортойг үйл ажиллагааг дэмжих бүтэц, Монгол Улсын нөхцөлд тохируулан нутагшуулах чиглэлээр судалж, судалгаа бэлтгэсэн. Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмын дагуу боловсруулан ажиллаж байна.	
7.1.2	Төрийн болон бусад байгууллагуудыг орон зайн суурь мэдээллээр ханган ажиллах боломжийг бүрдүүлэх, солилцох ажлыг зохион байгуулах	-	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	80	90	Байгууллагын орон зайн суурь мэдээллийг тогтмол шинэчлэх, шаардлагатай өгөгдлийг бусад системүүдээс холбох, солилцох ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу байгууллагаас 22 орон зайн өгөгдөл, мэдээлэл, 3 сервисийг Онцгой байдлын ерөнхий газрын цахим системд нийлүүлэхээр тусгагдаж, холбогдох үйлчилгээг гаргахаар ажиллаж байна. Мөн Нийслэлийн замын хөгжлийн газартай хамтран ажиллах гэрээг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулж, тус гэрээгээр 11 орон зайн өгөгдөл мэдээлэл, 7 сервисийг нийлүүлэхээр тусгасан. Дундын мэдээллийн сангаас өгөгдөл, сервисийг холбохоор Софт мастер ХХК-тай хамтран ажиллаж байна.	50
8.1	Салбарын үйл ажиллагаанд	Гадаадын		60	80	Зорилтын хэрэгжилт 73.5 хувьтай байна.	

	ашиглагдаж байгаа болон шинээр хэрэглээнд нэвтрүүлэх системүүдийн нэмэлт хөгжүүлэлт хийх, хэрэглээнд нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангана.	хөрөнгө оруулалт, Орон нутгийн төсөв	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь				
8.1.1	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системүүдэд хөгжүүлэлт хийх	-	Хөгжүүлэлтийн тоо	1	2	"Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем"-ийг Татварын ерөнхий газрын "Татварын удирдлагын нэгдсэн систем"-тэй холбох хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр иргэн, хуулийн этгээд газрын эрх шилжүүлэх хүсэлтийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn)-ээр дамжуулан гаргах үед холбогдох баримт бичгийг "Татварын удирдлагын нэгдсэн систем"-д цахимаар илгээж Газрын эрх шилжүүлсний орлогын албан татварын нэхэмжлэхийг үүсгэн цахимаар татвар төлөх боломжийг бүрдүүлсэн. Дэд систем болох Газрын кадастрын систем, Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (Egazar.gov.mn), Egazar гар утасны аппликейшнд нэмэлт хөгжүүлэлт хийх 23 иж бүрдэл бүхий ажлын даалгаврын төслийг боловсруулсан. Мөн иргэн, хуулийн этгээдийн газрын эрх шилжүүлэх хүсэлтийг нотариатын байгууллагаар дамжуулан шууд хүлээн авах системийн нэмэлт хөгжүүлэлтийн 17 иж бүрдэл бүхий ажлын даалгаврын батлан ажил гүйцэтгэх гэрээ байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем болон Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн геопортал цахим системд Улаанбаатар хотын дагуул Хүннү хотын нутаг	50

						дэвсгэрийн мэдээллийг оруулах” нэмэлт хөгжүүлэлтийн ажлын даалгаврын төслийг боловсруулж, Хүннү хотын захирагчид 2026 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 1/663 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	
8.1.2	Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Гадаадын хөрөнгө оруулалт	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	5	25	Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж, нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 516,963 нэгж талбар, 318,510 барилгын орц, гарц, 41,589 гудамж, замыг зураглан газар болон үл хөдлөх, эд хөрөнгөд шинээр хаяг олгох ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем /www.egazar.gov.mn/-д шинэ хаягийн мэдээллийг нээлттэй байршуулсан. Нийслэлийн хэмжээнд 41,589 гудамж, замыг харьяалах Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн нэршүүлэхээс 27,500 гудамж, замыг нэршүүлж, Хаягийн мэдээллийн нэгдсэн системд баталгаажуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Хаягийн мэдээллийн системийг шинэчлэх замаар Монгол Улсын цахим төрийн удирдлагыг бэхжүүлэх төсөл”-ийг 2026- 2029 онд 8 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр Бүгд Найрамдах Солонгос Улсын КОЙКА Олон Улсын хамтын ажиллагааны байгууллагатай хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурсан бөгөөд Сангийн яамаар баталгаажуулахаар хүргүүлсэн.	66.1
8.1.3	Улсын хэмжээнд газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын системийг хэрэглээнд	-	Системийг нэвтрүүлсэн аймгийн тоо	-	21	Улсын хэмжээнд Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын системийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлсэн.	80

	нэвтрүүлж, хэвийн үйл ажиллагааг хангах					<p>- 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/883 дугаартай албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хяналт шалгалт болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тус системээр дамжуулан хэрэгжүүлэх чиглэлийг хүргүүлсэн.</p> <p>- 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Салбарын хяналт шалгалтын хэлтэс болон 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчдад "Хяналт шалгалтын систем"-ийн цахим сургалт зохион байгуулсан.</p> <p>Хагас жилийн байдлаар улсын хэмжээнд цахим системд 133 гомдол, мэдээлэл, төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж 30, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж 3, зөрчлийн хэрэг 29 бүртгэж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан.</p>	
8.1.4	Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	50	<p>Орхон, Өмнөговь, Говьсүмбэр, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хамаарах "Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил"-ын үр дүнд хяналт, шалгалт хийх Ажлын хэсгийг 2026 оны А/72, А/73, А/74, А/75 дугаар тушаалаар байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 4 удаа зохион байгуулсан.</p> <p>Тус аймгуудын нутаг дэвсгэрт хамаарах "Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил"-ын үр дүнд хяналт, шалгалт хийж Ажлын хэсгийн гишүүдийн ирүүлсэн тайланг, нэгтгэсэн.</p>	75
			Хамрагдсан аймгийн тоо	-	5		
8.1.5	Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх	-	Үйлчилгээ үзүүлсэн хувь	-	100	<p>-Газрын нэгж талбарын түүхчилсэн лавлагааны системээс нэгж талбарын түүхчилсэн лавлагаа, агаар сансрын зураг болон давхцалын зурган</p>	100

						<p>мэдээллийг тус тус гарган авах боломжтой болсон ба хагас жилийн байдлаар 23 иргэн, хуулийн этгээдээс үйлчилгээ авах хүсэлт ирсний дагуу лавлагаа, мэдээллээр хангасан.</p> <p>-Салбарын Архивын цахим системээр 20 иргэн, хуулийн этгээдээс үйлчилгээ авах хүсэлт ирсний дагуу лавлагаа, мэдээллээр хангасан.</p>	
8.1.6	Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлах, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	<p>"Цахимаар нэн тэргүүнд (digital first)" бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөнд тусгасан дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>1. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "E-Mongolia"-д гарч буй цахим үйлчилгээний тоог нэмэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор "И-Монголиа" УТҮГ-тэй хамтран тусгай зөвшөөрөл болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал тусгах 30 үйлчилгээг холболт (link) хийж ажиллаа. Тус үйлчилгээнүүд нь E-Mongolia үйлчилгээ хэсгээс илэрц харагдах бөгөөд тус байгууллагын холбогдох цахим системүүд рүү үсэрч, үйлчилгээг авах боломжтой болсон.</p> <p>2. Хэрэглэгчид хэрэглэхэд тохиромжтой интерфэйс (user friendly UI/UX)-ийн судалгааг хийсэн. Үйлчилгээг хэрэглэгчийн ялгаатай байдал (нас, байршил, хөгжлийн бэрхшээлтэй иргэн г.м)-аас үл хамаарч эрх тэгш боломжийг бүрдүүлэх зорилгоор олон улсад мөрдөгддөг жишиг стандарт болох WCAG (Web Content Accessibility Guidelines)-ийг судалж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй (харааны, сонсголын, хөдөлгөөний) иргэдэд зориулсан тусгай горим, хүртээмжтэй шийдлүүдийг тодорхойлсон.</p>	70

						<p>3. Тус газраас төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал болох “И-Монголиа” руу гарч буй үйлчилгээнүүдийг Монгол болон Англи хэлээр авах боломжийг бүрдүүлэх зорилгоор одоогийн байдлаар ГНСУНЦС-ийн 6 үйлчилгээг Англи хэл дээр мэдээлэл гаргахаар ажиллаж байна.</p> <p>4. Цахимаар нэн тэргүүнд бодлогын зөвлөмжийн ижил үүрэг бүхий мэдээллийн системийг давхардуулж хөгжүүлэхгүй байх, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар албан даалгаврын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дараах 11 мэдээллийн системийг Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн нэгдсэн системд (system.gov.mn) бүртгэсэн. Үүнд: Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем; Газрын үнэлгээний систем; Дундын мэдээллийн сан; Газрын биржийн систем; Салбарын хяналт шалгалтын систем; Хилийн цэсийн мэдээллийн сан; Газрын мониторингийн систем; Газрын нэгдмэл сангийн систем; Салбарын сургалтын цахим систем; Үндэсний орон зайн өгөгдлийн Геопортал цахим систем; Газрын төлбөр, татварын систем. Дээрх систем тус бүрээр Үндсэн мэдээлэл, Дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ, аудит, Гэрээ, Өгөгдөл, мэдээлэл, Мэдээллийн сан, Ашигласан технологи, дэд бүтэц, Ашиглалт, үйл ажиллагаа, Зохиогчийн эрх, Санхүүжилт, Хариуцаж буй албан хаагч гэсэн 10 бүлэг бүхий 94 асуултыг бүрэн бөглөж, бүртгэлийг баталгаажуулсан болно.</p>	
9.1	Газрын харилцааны салбарын бодлого,	-	Тухайн жилийн арга	92	97.8	Зорилтын хэрэгжилт 87.9 хувьтай байна.	

	стратегийг судалгаанд суурилан боловсруулж, хэрэгжилт, уялдааг хангах замаар салбарын тогтвортой хөгжлийг удирдан чиглүүлнэ.		хэмжээний хэрэгжилтийн хувь				
9.1.1	Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2026 оны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	86	100	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг шинэчлэн 2026 оны А/86 дугаар тушаалаар, “Байгууллагын эрсдэлийн удирдлагын үнэлгээ хийх аргачлал”-ыг А/87 дугаар тушаалаар тус тус баталж, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Харьяа 22 байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийж зөвлөмж хүргүүлж, хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. - “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын цахим систем”-ийн сургалтыг зохион байгуулж, цахимаар 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчид, танхимаар тус газрын албан хаагчдыг хамруулсан. - “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын цахим систем”-д гүйцэтгэлийн төлөвлөгөө, явцын тайлан оруулж, хөтлөх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулсан. - Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 	50
9.1.2	Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг	-	Хэрэгжилтийн хувь	90	100	Тус газрын нийт 188 тушаал, албан хаагчдаас болон бусад холбогдох	

	боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих					байгууллагаас боловсруулсан 44 ажил гүйцэтгэх болон хамтран ажиллах гэрээ гэрээний төслийг хянан эрх зүйн үндэслэлийг хангуулан, хяналт тавин ажилласан.	100
9.1.3	Захиргааны актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох	-	Хэрэгжилтийн хувь	90	100	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газрын тухай, газрын төлбөрийн тухай, кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, геодези, зураг зүйн тухай, хаягжуулалтын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд батлуулахаар заасан журам, аргачлалын жагсаалтад дүн шинжилгээ хийн, батлагдаагүй эрх зүйн актуудын жагсаалт гаргаж, батлуулах шаардлагатай журмуудын жагсаалтыг холбогдох нэгжүүдэд хүргүүлж ажлын хэсэг байгуулсан. Үүнд: 1."Газрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, мэдээлэл солилцооны журам"-ыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/105 тушаал; 2."Хориглох дохио тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журам"-ыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/106 дугаар тушаал; 3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам руу нөхөн сэргээлтийн журам, заавар, аргачлал боловсруулах ажлын хэсэг байгуулах, хамтран ажиллах 1/1496 дугаар албан бичгийг 2026 оны 05 дугаар 18-ны өдөр хүргүүлсэн. -"Хилийн цэсийн, газар усны нэрийн болон газрын сангийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах журам"-ыг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/441 дугаартай тушаалаар баталсан. 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/1443 дугаартай албан бичгээр захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүргүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	100

9.1.4	Төсвийн саналыг боловсруулж, хуваарилах, хэрэгжилтэд тавих	төслийн нэгтгэн хүргүүлэх, хяналт	-	Хэрэгжилтийн хувь	95	98	<p>2027 оны төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/1717 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Харьяа газруудаас 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 1/1173 дугаар албан бичгээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн саналыг, 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 1/1737 дугаар албан бичгээр урсгал үйл ажиллагааны орлого, зарлагын төсвийн саналыг тус тус авч, хуулийн хугацаанд хүргүүлэхээр нэгтгэн боловсруулж байна.</p>	90
9.1.5	Байгууллагын санхүүгийн ажиллагааг байгуулж, хэрэгжүүлэх	үйл зохион тогтвортой	-	Хэрэгжилтийн хувь	92	95	<p>Монгол Улсын Сангийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 24 дүгээр тушаалаар 2025 оны үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого болох 1,879.1 сая төгрөгийг зарцуулах эрхийг олгосны дагуу 2025 онд үүссэн өр төлбөрийг холбогдох хууль, журмын дагуу төлж барагдуулсан.</p> <p>Байгууллагын 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд салбарын үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 2026 оны 1/449, 1/640, 1/726, 1/779, 1/1155 дугаар албан бичгийг тус тус хүргүүлж, Сангийн ямаар шийдвэрлүүлэн ажиллаж байна. 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад үүсэж болзошгүй хүндрэл, нөхцөл байдлыг тодорхойлж, хүлээгдэж буй гүйцэтгэлийн судалгаа тооцоог харьяа 22 байгууллагаас авч нэгтгэн, нийт 23 байгууллагад 9,929.0 сая төгрөгийн төсөв дутагдах тухай мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 05</p>	94.7

						дугаар сарын 26-ны өдрийн 1/1583 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
9.1.6	Өмч хөрөнгийн бүртгэлжүүлэлт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих, тайлагнах, дүгнүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	94	96	Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 5 удаагийн хурлаар агентлаг, харьяа газруудын хөрөнгийн холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 1/555 дугаар, 1/1049 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны салбарын хэмжээнд үндсэн хөрөнгө актлах, ашиглах жил бүр үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад шилжүүлэх 474, 480, 481, 488, 498, 611, 673, 669, 691, 717, 760 дугаар тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 1/891 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.	83.3
9.1.7	Байгууллагын санхүүгийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд тайлагнах, дүгнүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	94	96	Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн сарын мэдээг 1/25, 1/394, 1/628, 1/1286, 1/1673 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/290 дүгээр албан бичгээр Байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/647 дугаар албан бичгээр Байгууллагын 2025 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тус тус хүргүүлж, санхүүгийн аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэгдсэн. Байгууллагын аудитлагдсан 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1/895 дугаар албан бичгээр хүргүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн.	93.7

						<p>Мөн Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, Хувь хүний орлогын албан татаварын тайланг хуулийн хугацаанд баталгаажуулан, тайлагнасан. Байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, www.shilen.gov.mn цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд оруулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Улирал бүр шилэн дансны нэгдсэн тайланг гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 1/292, 1/1061 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.</p>	
9.1.8	Салбарын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах	-	Хэрэгжилтийн хувь	95	98	<p>Тус газрын 2025 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга тайлбарыг холбогдох хууль, журмын дагуу иж бүрэн бэлтгэх ажлын хүрээнд харьяа газруудын санхүүгийн тайланг дансны үлдэгдлийн баталгаа, тооцоо нийлсэн акт зэрэг баримт материалтай тулган хянан шалгаж, нэгтгэн хүлээн авсан.</p> <p>Үндэсний аудитын газраас 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/1050 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаар албан даалгаврын хүрээнд төсвийн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай чиглэлийг харьяа газруудад 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1104 дүгээр албан бичгээр хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна. Газрын харилцааны салбарын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж буй тус газрын</p>	91.8

						дарын 2023 оны А/157 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлтэй холбоотой шинэчлэгдсэн стандарт, хууль журмын өөрчлөлтийг тусган, 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар баталж, мөрдөн ажиллаж байна.	
9.2	Салбарын төрийн архив болон байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож, цахимжуулалт, нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	91	100	Зорилтын хэрэгжилт 70.6 хувьтай байна.	
9.2.1	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	100	Тус газарт тайлант хугацаанд нийт 2281 албан бичиг ирснийг ABLE системд бүртгэсэн. Үүнээс: 1164 хариугүй албан бичиг, 1117 хариутай албан бичиг ирсэн. Хариутай албан бичгийн 1060 албан бичгийг хугацаандаа шийдвэрлэсэн, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 57 албан бичиг, хяналтад 65 албан бичиг байна.	40
9.2.2	Байгууллагын архивын ажлын 2026 оны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	100	Байгууллагын 2026 оны архивын ажлын төлөвлөгөө боловсруулсан. 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр ABLE удирдлагын системийн олон нийт хэсэгт "Архив, бичиг хэргийн эрхлэгч нарын мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө цахимаар олгох өрөө"-г үүсгэн, архивын 12 ажлын чиглэлээр төлөвлөгөө гарган байршуулж 8 төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	60
9.2.3	Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангах	-	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн хувь	82	95	Мэдээллийн ил тод нээлттэй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд 5 бүлгийн 55 төрлийн мэдээлэл, www.opendata.gov.mn байрших газрын харилцааны салбартай холбоотой 5 бүлгийн 75 төрлийн нийт 130	88

						нэр төрлийн мэдээллийг шинэчилж байршуулав. 2026 оны хагас жилийн байдлаар 88% тай үнэлэгдэв. www.opendata.mn дээрх мэдээлэл бүрэн шинэчлэгдэв.	
9.2.4	Байгууллагын дата төвийн техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ашиглагдаж буй программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	-	Хэвийн үйл ажиллагааг хангасан эсэх	Хэвийн үйл ажиллагаа г хангасан	Хэвийн үйл ажиллагаа г хангана.	-Техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах хүрээнд: Дата төвийн 6 дахь rack (рак)-ны 192.168.20.21 IP хаягтай серверт үүссэн асуудлыг илрүүлж, шатсан байсан 2 ширхэг 1.2TB SAS хард дискийг солин, серверийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлсэн. Дата төвийн 10 дахь rack (рак)-ны серверүүдэд нийт 15 ширхэг хард диск шатсаныг " 13 хард дискийг солих, угсрах ажлыг хийж гүйцэтгэсэн. Гэнэтийн гамшиг, осол, гэмтэл саатал гарах үед хэвийн ажиллагаа алдагдахаас сэргийлж байгууллагын дата төвд байрлаж буй системүүдийг толин (mirror) хэлбэрээр Үндэсний дата төвд байршуулахаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 1/433 дугаар албан бичгээр, Үндэсний дата төвд 1/430 дугаар албан бичгээр тус тус хүсэлт хүргүүлж, Үндэсний дата төвийн инженерүүдтэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж, шаардлагатай мэдээлэл, материалыг 6 удаа хүлээлгэж өгсөн. Үр дүнд 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн ЗС/26-29 дугаартай гэрээг байгуулан дата төвийн толин хувилбарыг Үндэсний дата төвд үе шаттайгаар байгуулах ажлыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамд 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 1/1407 дугаар албан бичгээр нөөц дата төвийг Дархан-Уул аймаг дахь Үндэсний дата төвд байгуулах хүсэлтийг хүргүүлж, Үндэсний Дата Төвийн холбогдох инженерүүдтэй	100

						уулзалт зохион байгуулж, нөөц дата төв байгуулах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Программ хангамж, цахим системүүдийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд: 2026 онд Газрын нэгдмэл сангийн Удирдлагын цахим системтэй холбоотой 60 орчим асуудал, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системтэй холбоотой 13 удаагийн доголдлыг хэвийн үйл ажиллагаанд шуурхай шилжүүлэн ажилласан. Нотариат, ХУР систем, ДАН систем, бусад цахим системүүдийн доголдолтой холбоотой 50 гаруй засварыг хийж гүйцэтгэсэн.	
9.2.5	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнах нэгтгэн	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Хугацаанд нь тайлагнасан.	Хугацаанд нь тайлагнана.	Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2026 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг тус тус нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төслийг аргачлалын дагуу боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 1/159 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	90
9.2.6	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнах	-	Хугацаандаа тайлагнасан эсэх	Хугацаанд нь тайлагнасан.	Хугацаанд нь тайлагнана.	Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан (https://new.unelgee.gov.mn/law/)-д тайлант хугацаанд Монгол Улсын 5 хуулийн 7 заалт, УИХ-ын 11 тогтоолын 13 заалт, УИХ-ын Байнгын 6 тогтоолын 14 заалт, Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 2 заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмжийн 2 заалт, Засгийн	100

					<p>газрын 63 тогтоолын 81 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт, Засгийн газрын хуралдааны 36 тэмдэглэлийн 63 заалт, Засгийн газрын 3 албан даалгаврын 25 заалт, нийт 194 заалт хяналтад байгааг бүртгэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд тусгагдсан арга хэмжээг тодорхой үр дүнтэй хэрэгжүүлснээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын биелэлт 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар 78.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар 6 асуудал оруулан хэлэлцүүлж салбарт хамааралтай нийт 3 тогтоол, ерөнхий сайдын 4 захирамж, хуралдааны 2 тэмдэглэл, нийт 9 шийдвэрийг тус тус батлуулсан.</p> <p>Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д:</p> <p>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн байдлаар тайлагнаж, 2026 оны 01 дүгээр сарын 14-ний 1/137 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p> <p>Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо” цэсэнд 1 заалт; Засгийн газрын 2026 оны 02 дугаар албан даалгаврын 4 заалт; Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2026 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтийг цаглабарын дагуу тайлагнасан.</p> <p>“Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар”-ын цэсэд Засгийн газрын 2026 оны 115 дугаар тогтоолын 2 заалт, 119 дүгээр тогтоолын 3 заалт, 127 дугаар тогтоолын 1 заалт, Засгийн газрын 2026</p>
--	--	--	--	--	---

						оны 05 дугаар албан даалгаврын 2 заалт, 06 дугаар албан даалгаврын 3 заалт, нийт 11 заалтын хэрэгжилт; Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээ”-ний 2 арга хэмжээ; Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөнд туссан 1 заалтыг тус тус цаглабарын дагуу хугацаандаа тайлагнасан.	
9.2.7	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	98	100	<p>Гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу НҮБ-ын Хоёрдугаар Захиргааны Түвшний Хил Хязгаар (SALB) хөтөлбөрт Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хилийн мэдээллийг илгээсэн.</p> <p>Азийн хөгжлийн банкны Бэлчээрийн газрыг нөхөн сэргээх төслийн танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>Дэлхийн газрын засаглалын индексийн Бэлчээрийн газрын эрхийн индексийг танилцуулах сургалтууд болон Дэлхийн бодлогын хэлэлцээрийн талаарх уулзалтуудыг Олон Улсын Газрын Эвсэлтэй хамтран зохион байгуулсан.</p> <p>БНСУ-ын Олон улсын хот байгуулалтын сургалтын төвөөс Тогтвортой газрын менежмент болон засаглалын тогтолцоо сэдвийн хүрээнд хүний нөөц чадавхижуулах сургалт авах тухай хүсэлтийг хүргүүлсэн.</p> <p>Удирдлага, албан хаагчдын 2023-2025 онд гадаад улсын төлөөлөгчидтэй хийсэн уулзалт, яриа, хэлэлцээрийн тэмдэглэл,</p>	50

						<p>байгуулсан гэрээ, санамж бичгийн тухай мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн төлөөлөгчидтэй уулзаж, тоног төхөөрөмж хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>Азийн хөгжлийн банкны Хараат бус үнэлгээний ажлын хэсгийн төлөөлөгчдийг хүлээн авч, Аймаг, сумдын ногоон бүсийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах тухай уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн хорооны Ази, Номхон далайн бүс нутгийн дэд хорооны Гүйцэтгэх зөвлөлийн хуралд 1 албан хаагч оролцсон.</p> <p>НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн Ази, Номхон далайн бүсийн хорооны ажлын хэсгүүдэд Монгол Улсыг төлөөлөн оролцох гишүүдийн мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн.</p> <p>Франц Улсын IGNFI байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хамтран хэрэгжүүлэх боломжтой төслийн саналуудыг нэгтгэн хүргүүлсэн.</p> <p>“Хаягийн мэдээллийн системийг шинэчлэх замаар Монгол Улсын цахим төрийн удирдлагыг бэхжүүлэх төсөл”-ийн хэлэлцээрийн протоколд гарын үсэг зурах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын оролцогч Талуудын 17 дугаар Бага хурал (COP17)-д оролцох бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.</p>	
9.2.8	Салбарын хэмжээнд судалгаа шинжилгээний	-		1	2	Бүгд Найрамдах Эстони Улс болон Бүгд Найрамдах Литва Улсын Газрын	50

	ажил эрхэлж, олон улсын дэвшилтэт техник, технологийг хэрэглээнд нэвтрүүлэх		Хэрэглээнд нэвтрүүлсэн тоо (өссөн дүнгээр)			татварын тухай хууль эрх зүйн судалгаа хийсэн. Төв Азийн улсуудын газрын харилцааны салбар, газар ашиглалтын бодлогын судалгааг бэлчээрийн газрын хууль эрх зүйн орчинд үндэслэн хийсэн. Газрын харилцаа болон засаглалтай холбоотой олон улсын индексүүдийн судалгааг хийсэн. НҮБ-ын Дэлхийг геодезийн тэргүүн туршлага хуваалцах төвийн боловсруулсан Дэлхийн Геодезийн хамтарсан Хөгжлийн 1-р Төлөвлөгөөг Монгол Улсад хэрэгжүүлэхээр эх баримт бичгийг орчуулж байна.	
9.2.9	Салбарын архивын сан хөмрөгийн баримтыг тогтоосон журам, стандартын дагуу хадгалж, хамгаалах төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	96	98	Төрийн архивын сан хөмрөгт хэсэгчилсэн тооллого хийх ажлын удирдамжийг 2026 оны А/31 дугаар тушаалаар баталсан. Байр зүйн сан хөмрөг, Газар зохион байгуулалтын сан хөмрөгийн нийт 9 дансны 4851 хадгаламжийн нэгжийн баримтад хэсэгчилсэн тооллого хийж “Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын дагуу техник боловсруулалт хийсэн. Хан-Уул дүүргийн 2003-2015 онд өмчлөх эрх үүссэн 135 хадгаламжийн нэгжийн 6050 нэгж талбарын хувийн хэргийг цахимжуулан “Архивын цахим систем”-д холбож, бар коджуулсан. Тус дүүргийн нийт 431 хадгаламжийн нэгжийн 15041 нэгж талбарын хувийн хэргийн 40,2%-ийг цахимжуулаад байна.	50
9.2.10	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	84	100	Байгууллагад 2026 оны 06 дугаар сарын байдлаар байгууллагад нийт 636 өргөдөл гомдол ирүүлсний 634 өргөдөл гомдол хариутай байна үүнээс шийдвэрлэсэн 562, хяналтад байгаа 72, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 11 өргөдөл, гомдол, шийдвэрлээгүй хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол 0 байна.	50

9.2.11	Төрийн болон албаны нууцын үйл ажиллагааг зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь	96	98	<p>Төрийн болон албаны нууцын тухай хууль, журам түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд” сэдэвт сургалтыг 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Тагнуулын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан.</p> <p>Тус сургалтад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын албан хаагчид, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны нууц хамгаалах ажилтнууд нийт 102 албан хаагч цахимаар болон танхимаар оролцсон.</p>	50
9.2.12	Цахимд суурилсан газрын нэгдсэн лавлах 1800-0101 тусгай дугаараар иргэдэд үйлчлэх ажлыг зохион байгуулах	-	Дуудлага нэмэгдүүлсэн хувь.	2	5	<p>Цахимд суурилсан газрын нэгдсэн лавлах 1800-0101 тусгай дугаарт 2026 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 28474 дуудлага хүлээн авч үйлчиллээ. Ирсэн дуудлагыг төрөлжүүлэн авч үзвэл.</p> <ul style="list-style-type: none"> •Шинээр газар эзэмших – 17308 •Газрын мэдээлэл шалгуулах – 4470 •Газрын төлбөр- 563 •Егазар үйлчилгээ авах- 2215 •Газрын эрх шилжүүлэх- 1385 •Газрын хугацаа сунгах- 526 •Утасны дугаар – 913 •Барьцаа бүртгэл- 269 •Өмчлөх эрхтэй холбоотой - 288 •Цахим системийн алдаа – 175 •Эрхийн төрөл өөрчлөх 89 •Дуудлага худалдаа 29 •Киосктой холбоотой 27 •Хянан баталгаа 42 •Цахим системтэй холбоотой 22 •Тусгай зөвшөөрөл 29 •Зориулалт өөрчлөх 11 •Газрын зөрчил 14 •Гомдол 21 •Бусад 78 	100

						2025 оны эхний хагас жилийн мөн үетэй харьцуулахад 42.4%-р өссөн	
9.2.13	Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах	-	Шүүхээр шийдвэрлэгдэж буй нийт маргаанд газартай холбоотой маргааны эзлэх хувь	23.5	24	2026 оны эхний улирлын байдлаар нотлох баримт, газрын түүхчилсэн лавлагаа, нэгж талбарын хувийн хэрэг хүссэн нийт 154 хүсэлт ирсэн бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн захиргааны болон иргэний хэргийн шүүхээс 131, Авлигатай тэмцэх газарт нийт 16 нотлох баримт болон түүхчилсэн лавлагааг гаргаж албан бичгээр хүргүүлсэн. Газрын даргын тушаалаар Шинжээчийн дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 19-ыг байгуулж хэмжилт зураглалын ажлыг хийж гүйцэтгэн, холбогдох нотлох баримт болон Газрын удирдлагын нэгдсэн цахим системийн мэдээлэлтэй харьцуулан шинжилгээ хийж заасан хугацаанд шинжээчийн дүгнэлтийг хүргүүлж ажилласан.	90
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 10. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ ЗАМААР БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛНЭ.							
10.1	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх чиглэлээр үе шаттай ажил зохион байгуулах замаар байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	95	100	Зорилтын хэрэгжилт 58.3 хувьтай байна.	
10.1.1	“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	92	95	“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах 2026 оны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд төрийн захиргааны 73 албан хаагчийн цалингийн санг шинэчлэн баталж, 5 албан хаагчид зэрэг дэв шинээр олгож, 23 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан.	50

						<p>Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 16 албан хаагчийг шагнасан.</p> <p>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд эрүүл мэндийн шалтгаанаар 1, ар гэрийн гачигдлын улмаас 3 албан хаагчид цалинтай чөлөө олгож, 60 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. Нийтийн тээврийн болон хоолны хөнгөлөлтийг тогтмол олгож ажилласан.</p> <p>Түүнчлэн албан хаагчдын ажиллах нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, компьютер, техник хэрэгслийн хэвийн ажиллагааг тогтмол ханган ажилласан. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэгт хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн. Мөн соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж, 350 гаруй тамирчин оролцсон спортын тэмцээнийг зохион байгуулсан.</p>	
10.1.2	Албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	95	100	<p>2026 оны сургалтын төлөвлөгөөнд нийт 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс тайлант хугацаанд 21 сургалт, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 1000 гаруй албан хаагчийг хамруулсан.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнийг давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалтыг Монголын газар зохион байгуулалтын холбоо ТББ, Монголын газрын менежментийн нэгдсэн эвсэл ТББ, Монголын Геодези, Фотограмметр, зураг зүйн холбоо ТББ, Монголын Кадастрын холбоо ТББ-уудтай хамтран зохион байгуулж байна.</p> <p>-Геодези, зураг зүйн мэргэжлийн чиглэлээр 2 зөвлөх инженер, 5 мэргэшсэн инженер газар зохион байгуулалт,</p>	50

						геодези, зураг зүйн салбарын мэргэшлийн зэрэг олгох, сунгах мэргэжлийн болон тайлан хамгаалах шалгалтад амжилттай тэнцэж газрын даргын 2026 оны А/71, А/84, дугаар тушаалуудаар Зөвлөх инженер болон Мэргэшсэн инженерийн зэрэг олгосон. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтнүүдийн мэдээллийн санг хөтлөн ажиллаж байна.	
10.1.3	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, тайлагнах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	98	100	Төрийн албаны зөвлөлийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 15 заалт бүхий төлөвлөгөөг салбар зөвлөлийн даргаар 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталж, Сэлгэн шилжих зарын дагуу хүсэлт ирээгүй албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлуулахаар харъяа байгууллагуудаас ирүүлсэн захиалгын дагуу сонгон шалгаруулалтыг 5 удаа зохион байгуулж, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба болон 8 аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 37 сул орон тоог нөхсөн. Мөн 15 аймгийн 35 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зар Төрийн албаны зөвлөлийн цахим системд нийтлэгдэн шалгалтад оролцогчдын бүртгэлийг цахимаар хүлээн авч байна.	50
10.1.4	“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх” хүрээнд Авлигаас урьдчилан сэргийлэх, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	-	Сургалт, нөлөөллийн ажлын тоо	15	20	Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 46 дугаар тогтоол, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу Авлигатай тэмцэх газартай хамтран 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр танхим болон цахимаар нийт салбарын 320	50
			Хамрагдсан хүний тоо	252	300		

						<p>албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Тус сургалтаар Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан, нөхцөл, авлигын хор уршиг ба ангилал, авлигыг хэмжих аргачлал, төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ, авлигаас урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоо хяналтыг сайжруулах нь сэдвийн хүрээнд мэдээлэл өгсөн.</p>	
10.1.5	"Ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх" зорилтот жилийн төлөвлөгөө салбарын хэмжээнд хэрэгжүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	100	<p>Тус газраас "Ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан салбарын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/252, зорилтод жилийн шилжин явах тугны хуваарийг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 2/477 дугаар албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд тус тус хүргүүлсэн. Хагас жилийн байдлаар 8 дахь аймагт шилжин явах туг аялж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяа 22 байгууллагаас хүлээн авч нэгтгэсэн.</p> <p>Мөн газрын даргын "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын үйлчилгээний стандарт батлах тухай" 2026 оны А/62 дугаар тушаалыг 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 1/675 дугаар албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн</p>	50

						байгууллагын албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа үр дүнтэй, чанд мөрдүүлж ажиллахыг үүрэг болгосон.	
10.1.6	"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	-	Арга хэмжээний тоо	1	1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 44 дүгээр зарлигийн хүрээнд Ойн газраас "Түргэний гол цэцэрлэгт хүрээлэн"-д 2026.05.09-ний өдөр зохион байгуулсан арга хэмжээнд оролцож, агентлаг 425 ширхэг мод тарьсан. Салбарын хэмжээнд 2026 оны хаврын мод тарих үндэсний өдрийн хүрээнд нарс, хайлаас, улиас, голт бор, агч, бургас зэрэг нийт 3969 ширхэг мод тарьсан.	100
Нийт 79 арга хэмжээ, 87 шалгуур үзүүлэлт						Дундаж хувь	62.3

Төлөвлөгөөг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг

.....

Төлөвлөгөө тайлагнасан:

Төсвийн Шууд захирагч

.....

.....

/...../

(албан тушаал)

(гарын үсэг)

(огноо)

Тэмдэг

.....